



# ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС



[www.han-uul.hudulmur-halamj.gov.mn](http://www.han-uul.hudulmur-halamj.gov.mn)

# МЭНДЧИЛГЭЭ

---



Хан-Уул дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн хамт олны зүгээс Та бүхний амар амгаланг айлтган мэндчилье. Бид төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйл ажиллагааны төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар иргэдийг ажилтай, орлоготой болгохоор ил тод, түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан Халамжаас-Хөдөлмөрт зорилт тавин ажиллаж байна.

Цаашид энэхүү зорилтын хүрээнд хүн амын хөдөлмөрлөх эрхийг хангах боломж нөхцөлийг бүрдүүлж ажиллах хүчний мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх замаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэн зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл ядуурлын түвшинг бууруулах, хүн амын зорилтот бүлгүүдийн хэрэгцээнд тулгуурлан нийгмийн халамжийн тухай багц хуулийн дагуу тэтгэвэр, тэтгэмж, тусламж олгох, хөнгөлөлт үзүүлэх, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх зэрэг бодлого чиглэл баримтлан ажиллаж байна.

Хан-Уул дүүргийн Хөдөлмөр, халамжийн  
үйлчилгээний хэлтсийн дарга П.Амартүвшин

# ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨР ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

---

## Эрхэм зорилго

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлогыг орон нутагт хэрэгжүүлэн олон нийтийн оролцоо дэмжлэгт тулгуурласан үйлчилгээ, арга хэмжээг иргэдэд хөнгөн шуурхай, чанар хүртээмжтэй хүргэхэд оршино



Тус хэлтэс нь Нийслэлийн Хөдөлмөр, халамжийн газрын даргын 2023 оны 01-р сарын 23-ны өдрийн А/03 тушаалаар орон тоо бүтэц батлагдаж 63 ажилтан, албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Хэлтсийн үйл ажиллагааг Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргааны нэгж, түүний удирдлагын тухай, Төрийн албаны тухай, Төсвийн тухай, Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Нийгмийн халамжийн тухай, Ахмад настны тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль болон Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын шийдвэр, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дүрэм болон холбогдох бусад хууль, тогтоомжоор зохицуулна.

Эдгээр хууль тогтоомж болон Монгол улсын Засгийн газар, Нийслэл, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг нийгмийн зорилтын заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах, хэрэгжилт үр дүнг тооцон тайлагнах талаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга болон Хан-Уул дүүргийн Засаг даргатай үр дүнгийн гэрээ байгуулан ажлаа сар, улирал, жилээр төлөвлөн ажиллаж байна.



**Хэлтсийн дарга**



**ЗАХИРГАА,  
ХЯНАЛТЫН  
ТАСАГ**



**НИЙГМИЙН  
ХАЛАМЖИЙН  
ТАСАГ**



**ХӨДӨЛМӨР  
ЭРХЛЭЛТИЙН  
ТАСАГ**

-  Захиргаа, хяналтын тасгийн дарга
-  Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
-  Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн
-  Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч
-  Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч
-  Үйл ажиллагааны ахлах нягтлан бодогч
-  Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн
-  Архив, бичиг хэрэг, даргын туслах
-  Программ хангамж, мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн
-  Нярав
-  Үйлчилгээний ажилтан

-  Нийгмийн халамжийн тасгийн дарга
-  Халамжийн сан, сангийн олголт хариуцсан ахлах мэргэжилтэн
-  Халамжийн сангийн олголт хариуцсан мэргэжилтэн
-  Нийгмийн халамжийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
-  Нийгмийн халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн
-  ОНОТХУ, зорилтот бүлгийн хүн ам өрхийн хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн
-  ӨМНС-ийн судалгаа, өргөдөл, гомдол хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа хариуцсан мэргэжилтэн


-  Хөдөлмөр эрхлэлтийн тасгийн дарга
-  Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан хариуцсан ахлах мэргэжилтэн
-  Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн
-  Хөдөлмөрийн харилцаа, ХАБ хариуцсан мэргэжилтэн



**Хөдөлмөр, эрхлэлт,  
халамжийн асуудал  
хариуцсан хорооны  
мэргэжилтэн 25**

# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН  
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ**



**НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЭХ**



**ХӨДӨЛМӨРИЙН БОЛОН  
ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ АХУЙН  
ХЯНАЛТ ХИЙХ**

